



НИЙСЛЭЛИЙН
НИЙТЛЭГ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ

2020 оны 05 сарын 28 өдөр

Дугаар А/34

Улаанбаатар хот

Хариуцлагатай эргүүл, жижүүр
томилох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5, Нийтээр тэмдэглэх баярын болон тэмдэглэлт өдрүүдийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.6, 4.1.10, Газрын хөдөлмөрийн дотоод журмын 2 дугаар зүйлийн 2.1, 2.1.7 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ НЬ:

1. Нийслэлийн Засаг захиргааны байруудад нийтээр амрах амралтын өдөр буюу Олон улсын хүүхдийн эрхийг хамгаалах өдөр, Бурхан багшийн Их дүйчин өдөр буюу билгийн тооллын зуны тэргүүн сарын шинийн 15-нд хариуцлагатай эргүүл, жижүүрээр ажиллах албан хаагчдын нэрсийг хавсралтаар баталсугай.

2. Нийслэлийн Засаг захиргааны байруудын цахилгаан, инженерийн байгууламжийн хэвийн жигд ажиллагааг хангаж, гал усны аюулаас урьдчилан сэргийлж, харуул хамгаалалтын ажилтнуудтай хамтран ажиллаж, гарсан зөрчил, доголдлыг шуурхай шийдвэрлэн, шаардлагатай арга хэмжээг цаг алдалгүй авч ажиллахыг хариуцлагатай эргүүл, жижүүрээр ажиллах албан хаагчдад үүрэг болгосугай.

3. Энэхүү тушаалын хэрэгжилтэнд хяналт тавьж, хэрэгжилтийн талаар газрын удирдлагад танилцуулж ажиллахыг Байр ашиглалтын албаны дарга /Г.Батзаяа/-д даалгасугай.


ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ



Х.ЭРДЭНЭБИЛЭГ

1150500067

Нийслэлийн нийтлэг үйлчилгээний газрын
даргын 2020 оны 25-р сарын 28-ны өдрийн
АБ дугаар тушаалын хавсралт



ХАРИУЦЛАГАТАЙ ЭРГҮҮЛ, ЖИЖҮҮРЭЭР АЖИЛЛАХ ХУВААРЬ

№	Нэр	Албан тушаал	Огноо	Утас	Тайлбар
1.	Б.Батцоож	Агентлаг хариуцсан ахлах нягтлан бодогч	2020.06.01	99847824	НЗЗ-ны байруудын инженерийн шугам сүлжээнд гэмтэл, доголдол гарсан тохиолдолд БАА-ны даргад яаралтай мэдэгдэж шуурхай арга хэмжээ авна.
2.	Н.Булганчимэг	Хүний нөөцийн ажилтан	2020.06.05	95008444	

Тайлбар: Хариуцлагатай эргүүлээр ажиллах хугацаандаа Нийслэлийн засаг захиргааны байруудыг /НЗЗ-ны 1, 2, 3, 4, 5-р байр, Баянхошуу бизнес инкубатор төв/-г өглөө 10:00 цагаас эхлэн 22:00 цаг хүртэл эргэж тойрч харуул, оператор, жижүүрүүдтэй нягт холбоотой ажиллаж, рапортын дэвтрийг хөтлөн Байр ашиглалтын албанд хүлээлгэн өгнө.